

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2015 ОНД
ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

(2015 оны жилийн эцсийн дүн)

Худалдан авах ажиллагааны газар

- Монгол Улсын Их Хурлын 2014 оны 53 дугаар тогтоолын хавсралтаар Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл батлагдсан.

2016.01.10

Улаанбаатар хот

Д/д	Урт ба дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2015 онд хүрэх түвшин, үр дүн	Хөрөнгийн эх үүсвэр /тэрбум төгрөг/	Хүрсэн түвшин, Биелэлт	Яам, агентлагийн үнэлгээ	Яамны үнэлгээ	Яамны үнэлгээний тайлбар
1	2	3	4	5	6	7	8	9	10
НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО									
Зорилт 3.Төсвийн тогтвортой, тэнцвэрт байдлыг хангах бодлого баримтлахын зэрэгцээ, санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.									
3.3	ҮХЦБ-ын 7.2 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 17.3, 17.4, 27.1 дэх заалт	Засгийн газрын худалдан авах ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох	Засгийн газрын нийт худалдан авалтад цахим худалдан авалтын эзлэх хувь	50 хувь	-	Засгийн газрын уралдааны 2015 оны 01 сарын 09-ний өдрийн 04 дүгээр тэмдэглэлээр “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хянан боловсруулж, 2015 оны 1 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд оруулах тухай” үүргийг Монгол Улсын Шадар сайд, Сангийн сайдад тус тус даалгасны дагуу ХААГ-аас хуулийн шинэчилсэн төслийг боловсруулж, тухайн үеийн Шадар сайдын Ажлын алба, Сангийн яаманд тус тус хүргүүлсэн. Уг төсөлд байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтээс болон хэрэглэгчдээс санал авч тусгасан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд	90 %		

					<p>тогтолцооны шинжтэй асуудал тухайлбал, орон нутгийн худалдан авах ажиллагааны эрх, үүргийг тодорхой болгох, худалдан авах ажиллагаанд тулгамдаж байгаа бусад асуудал, ойлголтын зөрүүг шийдвэрлэхэд чиглэсэн зүйл, заалтуудыг тусгасан болно.</p> <p>Монгол Улсын Шадар сайдын 2015 оны 08 сарын 03-ны өдрийн 94 дүгээр тушаалаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийг байгуулсан бөгөөд уг бүрэлдэхүүнд ШСАА-ны Ахлах зөвлөх, Сангийн яам, тус байгууллагын холбогдох төлөөлөл оролцсон бөгөөд уг Ажлын хэсэг ШСАА-нд нэг удаа хуралдаж, хуулийн төслийн асуудлаар санал солилцсон. Олон улсын судалгааны баг ажиллаж холбогдох судалгаа хийсний дараа хуулийн төслийг боловсруулах асуудлыг 2016 оны 05 сар хүртэл хойшлуулахаар төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас шийдвэрлэсэн тул хүлээгдэж байна.</p> <p>Мөн “Орон нутгийн Худалдан авах ажиллагааны нэгжийн ажиллах журам”-ын төслийг боловсруулан 9 аймаг, 2 дүүргийн саналыг тусгаж, 2015 оны 03 сарын 24-ний өдрийн 1/183 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулсан 50,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 151 багцад 45,3 тэрбум төгрөгийн гэрээ байгуулж, улсын төсөвт 5,5 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргасан. ХААГ-т зохион байгуулсан нийт тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулав.</p> <p>Харин орон нутгийн Худалдан авах ажиллагааны 31 нэгж тайлант жилд нийт 325,0 тэрбум төгрөгийн 2150 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас 304.0 тэрбум</p>		
--	--	--	--	--	---	--	--

					<p>төгрөгийн 1868 төсөл, арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд 667 төсөл, арга хэмжээний тендерийг цахим хэлбэрээр зарлан зохион байгуулав. Орон нутгийн нэгжүүд зохион байгуулсан худалдан авах ажиллагааныхаа 100 хүртэлх хувийг цахим хэлбэрээр зарлав.</p> <p>Улсын хэмжээнд 2015 онд нийт давхардсан тоогоор 1212 удаагийн тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан байна. Цахим худалдан авах ажиллагааны системийг ашиглан 2015 онд улсын хэмжээнд 3900 ААН давхардсан тоогоор нийт 4029 тендерийн саналыг цахим хэлбэрээр ирүүлэн тендерт оролцсоноос дүгнэхэд уг системийн хэрэглээ өмнөх жилүүдээс 2,5-5,6 дахин ахисан үзүүлэлттэй байна.</p>			
--	--	--	--	--	---	--	--	--

ХЯНАСАН:
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ЖАРГАЛАН

БОЛОВСРУУЛСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ